**ХУЛД СУМЫН ГАЗРЫН ДААМЛУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

| Үйл ажиллагааны чиглэл | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хэрэгжилт | Оноо | Үнэлгээ |
|---|---|---|---|---|
| **1. Захиргаа, дотоод ажлын явц, үр дүн** | | | **100** | **85** |
| **1.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжилт** | **1.1.1. Тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайлан /10 оноо/**<br>- Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын дагуу тайлагнасан байдал<br>- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, зохион байгуулалтын арга хэмжээг авсан байдал | Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөг хагас бүтэн жилээр тайлагнаж дүгнүүлдэг.<br>Гүйцэтгэлийн төлөвлөгөөг хагас жилээр 86 хувьтай дүгнүүлсэн. Эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээ байхгүй.<br>**Зөвлөмж:** Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнахдаа тоо баримттай, хүрсэн үр дүнтэй, тодорхой, бодитой тайлагнаж байх. | **20** | 15 |
| | **1.1.2. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт /5 оноо/**<br>- Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан байдал, хэрэгжилт, үр дүн | Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт сумын газар усны нэрийн тодруулалт, мэдээллийн сан үүсгэх ажлын төсвийг 2023 оны сумын орон нутгийн төсөвт тусгуулахаар санал оруулсан. Хилийн цэсийн гаднах өвөлжөө, хаваржааны газрын нийт 40 зөрчил байгаагаас 2022 оны төлөвлөгөөнд 5 нэгж талбарыг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган шийдвэрлэсэн байна.<br>**Зөвлөмж:** Бусад хил залгаа сумдын хилийн цэсийн маргаантай байгаа асуудлыг 2023 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган шийдвэрлэх<br>2023 оны сумын орон нутгийн төсөвт газар усны нэрийн тодруулалт, мэдээллийн сан үүсгэх ажлын төсвийг тусгаж, ажлыг гүйцэтгүүлэх | | |
| **1.2 Хууль, тогтоомжийн хэрэгжилт, тэдгээрийг сурталчилах** | **1.2.1. Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, сурталчилах /10 оноо/**<br>- Салбарын хууль, тогтоомжийг сурталчилсан байдал<br>- Шинэлэг ажил зохион байгуулсан байдал<br>- www.egazar.gov.mn сайтыг сурталчилсан байдал | Салбарын хууль, тогтоомж, www.egazar.gov.mn сайтыг багийн иргэдийн нийтийн хурлаар мэдээлэл хийж, гарын авлага тараадаг. 2022 онд 2 удаагийн хурлаар 170 гаруй иргэнд мэдээлэл хийж хууль тогтоомж, сайтаа сурталчилсан. | **30** | **20** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | - Цахим хуудсанд салбарын үйл ажиллагааг сурталчилсан байдал | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний зургийг 4 багийн дарга нарын өрөөнд байршуулж, иргэдийг мэдээллээ хангаж ажиллаж байна.<br>"Хулд сумын Засаг даргын тамгын газар" фэйсбүүк хуудсаар газрын харилцааны чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааг тогтмол сурталчилдаг.<br>**Зөвлөмж:** Хулд сумын Газрын даамал фэйсбүүк хуудасны үйл аиллагааг сайжруулах, мэдээлэл тогтмол тавьж байх.<br>Газрын харилцааны чиглэлээр жилд 1 ажлыг санаачлан зохион байгуулах. | | |
| **1.3. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилт** | **1.3.1. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилт**<br>- Ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл бөглөсөн байдал<br>- Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилт | Ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэх хуудсыг сумын Засаг даргаар захирамж гарах бүрт бөглөж бичиг хэрэгт өгдөг.<br>Авлигатай тэмцэх газраас 2 дугаар сард төрийн албан хаагчдад зохион байгуулсан цахим сургалтад хамрагдсан. | **10** | **10** |
| **1.4. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаар боловсронгуй болгох чиглэлээр зохион байгуулсан ажил** | **1.4.1. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны зохион байгуулалт /5 оноо/**<br>- Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, эмх цэгц<br>- Албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, түүний хувь<br>- Албан бичгийн бүрдэл, стандартын дагуу боловсруулж, албажуулсан байдал<br>- Тамга тэмдэгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт | Ирсэн, явсан бичиг, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын бүртгэлийн дэвтрийг хөтөлдөг.<br>2022 онд иргэдээс өргөдөл гомдол ирүүлээгүй.<br>Газрын даамал, хуулбар үнэн, хүчингүй, нөхөн олгов тамга тэмдгийн хадгалалт хамгаалалт сайн.<br>Албан бичгийг боловсруулж, хянуулаад бичиг хэрэг албажуулдаг. | **40** | **40** |
| | **1.4.2. Байгууллагын удирдлагын цогц програм хангамж /Эйбл/-ийн ашиглалт /5 оноо/**<br>- Албан хаагч тус бүрт ERP системд нэвтрэх эрх үүсгэгдэж, тогтмол ашигласан байдал<br>- ERP системийн ашиглалт, хэрэглээнд хяналт тавьж буй байдал /албан бичиг, цаг ашиглалт, үүрэг даалгавар, гэх мэт/ | ERP системийг өдөр тутам ашигладаг. | | |
| **2. Геодези, зураг зүйн үйл ажиллагааны явц, үр дүн** | | | **100** | **65** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **2.1. Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн мэдээллийн сангийн шинэчлэлт, өөрчлөлтийг хөтлөх, баяжуулах** | **2.1.1. “Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг хадгалах, хамгаалах, нүүлгэн шилжүүлэх журам”- ын хэрэгжилт**<br>- Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг хадгалах, хамгаалах ажлыг зохион байгуулсан байдал<br>- Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тооллого хийж, тооллогын тайланг ирүүлсэн байдал<br>- Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн мэдээллийн цахим санд нэмэлт өөрчлөлт хийж, баяжилт хийгдсэн байдал<br>- Олон нийтэд цэг, тэмдэгтийн бүрэн бүтэн байдлыг хангах талаар сурталчилсан байдал | Сумын хэмжээнд нийт 36 цэг тэмдэгт байдгаас төвийн 6 цэг тэмдэгт дээр тооллого зохион байгуулж, тайланг хүргүүлсэн. Шинээр үүссэн цэг тэмдэгт байхгүй учир баяжилт хийгдээгүй.<br>**Зөвлөмж:**Олон нийтэд цэг, тэмдэгтийн бүрэн бүтэн байдлыг хангах талаар сурталчилах<br>Үлдсэн цэг тэмдэгтийн тооллогыг нүд үзэн тоолж, тайланг ирүүлэх | **30** | 20 |
| **2.2. Байр зүйн зургийн мэдээллийн сангийн шинэчлэлт, өөрчлөлтийг хөтлөх, баяжуулах** | **2.2.1. “Байр зүйн дэвсгэр тоон зураг, инженерийн дэд бүтцийн мэдээллийн санг хөтлөх журам”-ын хэрэгжилт**<br>- Байр зүйн зургийн баяжилт хийсэн байдал, мэдээллийн сангийн цахим хөтлөлт<br>- Аймаг, орон нутагт хийгдсэн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэлийн зургаар хүлээн авсан байдал<br>- Журамд заасан бусад үйл ажиллагаа хэрэгжүүлсэн байдал<br>**2.2.2. Газар дээрх болон доорх шугам сүлжээний зураглалын ажлын явц болон гүйцэтгэлийн зургийг шалгаж хүлээн авч, мэдээллийн санг хөтлөх**<br>- Сум, суурин газарт хийгдсэн газар дээрх болон доорх шугам сүлжээний зургийг шалгаж хүлээн авч, гүйцэтгэлийн зургаар мэдээллийн сангийн шинэчлэлтийг серверт хандан хөтөлсөн байдал | Шинээр олгогдож буй нэгж талбаруудыг байр зүйн зурагт тухай бүр оруулж, баяжилт хийдэг.<br>**Зөвлөмж:** орон нутагт хийгдсэн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэлийн зургаар хүлээн авах<br>Сум, суурин газарт хийгдсэн газар дээрх болон доорх шугам сүлжээний зургийг шалгаж хүлээн авч, гүйцэтгэлийн зургаар мэдээллийн сангийн шинэчлэлтийг серверт хандан хөтлөх | **40** | 30 |
| **2.3. Монгол орны газар зүйн нэрийг тодотгон тогтоох, мэдээллийн сан үүсгэх** | **2.3.1. Монгол орны газар зүйн нэрийг тодотгон тогтоох ажлыг зохион байгуулах**<br>- Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулсан байдал<br>- Газар зүйн нэрийн мэдээллийн сангийн бүрдүүлэлт хийсэн байдал<br>- Газар зүйн үнэн зөв нэрийг ашиглах талаар олон нийтэд таниулан сурталчлах ажлыг зохион байгуулсан байдал | Газар зүйн нэрийн салбар зөвлөл 2022 онд 1 удаа хуралдаж шинээр газар зүйн нэрийн тодруулалтын ажил болон ажлын хэсэгт шинээр хүн нэмэх талаар ярилцаж санал бодлоо солилцсон.<br>**Зөвлөмж:** Газар зүйн нэрийн хээрийн тодруулалтын ажлыг зохион байгуулах, мэдээллийн сангийн бүрдүүлэлт хийх<br>Газар зүйн үнэн зөв нэрийг ашиглах талаар олон нийтэд таниулан сурталчлах ажлыг зохион байгуулах | **30** | 15 |
| **3. Суурь судалгаа, мониторингийн ажлын хэрэгжилтийн явц, үр дүн** | | | **100** | **75** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **3.1. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа** | **3.1.1. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ашиглалт, тайлагнал**<br>- Хот суурингийн газарт иргэн, хуулийн этгээдэд газар шинээр олгох тохиолдолд хамгийн сүүлд хийгдсэн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлын үр дүнг ашиглан, дүгнэлт гаргасан байдал | Хот суурингийн газарт иргэн, хуулийн этгээдэд газар шинээр олгохдоо 2013 онд АТТП ХХК-аас хийгдсэн хянан баталгааны дүгнэлтийг үндэслэн дүгнэлт гаргаж өгдөг. | **30** | **30** |
| | **3.1.2. Захиалгат хянан баталгааны ажлын бүртгэл, мэдээллийн сан, судалгаа, хяналт**<br>- Иргэн, хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр 5 жил тутамд, эрх шилжүүлэх, эрхийн хугацаа сунгах тохиолдлуудад хянан баталгааны ажил хийлгэсэн байдал | 2 аж ахуйн нэгж байгууллага газрын төлөв чанарын захиалгат хянан баталгааны ажлыг хийлгэж баталгаажуулсан. 5 иргэн, 9 аж ахуйн нэгж байгууллагад газрын төлөв байдал чанарын захиалгат хянан баталгаа хийлгэх мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн.<br>**Зөвлөмж:** Мэдэгдэх хуудас хүргүүлсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хянан баталгааны ажлыг хийж гүйцэтгүүлэх, эрх шилжүүлэх, эрхийн хугацаа сунгах тохиолдолд захиалгат хянан баталгаа хийлгэх. | **20** | **5** |
| **3.2. Бэлчээрийн фото мониторингийн систем** | **3.2.1. Бэлчээрийн фото мониторингийн хэрэгжилт**<br>- Тайлан гаргаж, өмнөх оны мэдээтэй харьцуулсан байдал<br>- Цэгүүдийн мэдээллийн сангийн бүрдэл, байршлын зураг, фото зургийн санг мэдээллийн сан, вэб програмд бүрэн оруулсан байдал<br>- Програм ашиглалтын байдал, мэдээллийн сангийн бүрдэл, цэгийн мэдээллийг бүрэн оруулсан байдал<br>- GPS багажны ашиглалт, бүрэн бүтэн байдал<br>- Хөрс, ургамлын багаж, төхөөрөмжийн ашиглалт, бүрэн бүтэн байдал<br>- Ажлын хэсэг байгуулж, хээрийн судалгааг мониторингийн цэгүүдэд бүрэн хийсэн байдал<br>- Бэлчээрийн фотомониторингийн тухайн оны үр дүнг холбогдох хурлуудаар хэлэлцүүлж, Газар зохион байгуулалтын төлөвлөлтөд тусгаж, хэлэлцүүлж, иргэдэд мэдээлэл хүргэсэн байдал | Бэлчээрийн фотомониторингийн ажлыг сумын хэмжээнд 08 сарын эхний 10 хоногт багтаан 16 цэг дээр хээрийн хэмжилт боловсруулалтын ажлыг гүйцэтгэж, газрын мониторингийн цахим системд боловруулалтын ажлыг бүрэн оруулсан.<br>**Зөвлөмж:**Тухайн оны үр дүнг сумын ИТХ-аар танилцуулж, 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд бэлчээр өнжөөх, бэлчээр ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт хийх арга хэмжээнүүдийг тусгаж ажиллах | **30** | **30** |
| **3.3. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн үндэсний сүлжээ** | **3.3.1. Газрын нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа**<br>- Нөхөн сэргээлт хийх газрын судалгааг ангилал тус бүрээр гаргасан байдал<br>- Нөхөн сэргээлт хийх газруудыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан байдал<br>- Нөхөн сэргээлтийг ажлын зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусгасан байдал<br>- Нөхөн сэргээлтийн ажлын хэрэгжилтийн байдал | 2021 онд сумын хэмжээнд 10га талбайд нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн. Энэ онд ашиглалт явагдаагүй.Нөхөн сэргээлт хийгдээгүй байна.<br>**Зөвлөмж:** Нөхөн сэргээлт хийх газрын судалгааг гаргаж , нөхөн сэргээлтийн ажлын зардлыг орон нутгийн төсөвт тусгуулж газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийн ажлыг хангах | **20** | **10** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | |
| **4. Газар зохион байгуулалтын төлөвлөлт, хэрэгжилтийн явц, үр дүн** | | | **100** | **70** |
| **4.1. Газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулалт, хэрэгжүүлэлт** | **4.1.1. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө /АГЗБЕТ/, түүний хэрэгжилт**<br>- Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнөөс тухайн жилд хийх ажлыг сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулах талаар авч хэрэгжүүлсэн байдал (5 оноо)<br>- Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнөөс тухайн онд төлөвлөсөн ажлыг хугацаанд нь хэрэгжүүлсэн байдал (5 оноо) | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнөөс тухайн жилд хийх ажлыг сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаагүй.<br>**Зөвлөмж**:Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнөөс тухайн жилд хийх ажлыг сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж ажиллах. | **10** | 0 |
| | **4.1.2. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт**<br>- Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаж вэб системд оруулсан байдал. (5 оноо)<br>- Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнөөс тухайн жилд хийх ажлыг сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулах талаар авч хэрэгжүүлсэн байдал. (5 оноо) | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаж вэб системд оруулаагүй.<br>**Зөвлөмж:**Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаж вэб системд оруулж, тухайн жилийн төлөвлөгөөнд тусгаж хэвших | **10** | 0 |
| | **4.1.3. Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, түүний хэрэгжилт**<br>- Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний боловсруулалт, хэрэгжилт (5 оноо)<br>- Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг ИТХ-ын тогтоолоор батлагдсан арга хэмжээний дагуу оруулж, баталгаажуулсан байдал (5 оноо)<br>- Цахим системд оруулж баталгаажуулсан арга хэмжээний дагуу тухайн жилд газар олголт хийгдсэн эсэх (10 оноо) | Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг журмын дагуу цахим системд боловсруулан оруулж арга хэмжээний дагуу газар олголт хийгдэж байна. 2022 онд 155 нэгж талбар төлөвлөсөн бөгөөд хэрэгжилт 90 хувтай байна. | **20** | **18** |
| | **4.1.4. Газар өмчлүүлэх ажлын зохион байгуулалт** | Өмчлөлийн газарт инженерийн дэд бүтэц бүрэн шийдэгдсэн 2022 онд 43 нэгж талбар төлөвлөсөн | **20** | **18** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | - Өмчлөлийн газарт инженерийн дэд бүтэц байгуулах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн байдал (5 оноо)<br>- Тухайн жилд өмчлүүлэхээр төлөвлөсөн газрын хэрэгжилт (5 оноо)<br>- Газар өмчлөлийн төлөвлөлт, түүний хэрэгжилтийг цахим бүртгэлийн системд бүрэн хамруулсан байдал (10оноо) | бөгөөд 100 хувь өмчлүүлсэн. Цахим системд оруулаагүй байна. | | |
| | **4.1.5. хамгаалалтын бүс, зурвас газрын мэдээллийн сан хөтлөх**<br>-Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд хууль тогтоомжийн дагуу тогтоосон хамгаалалтын бүс, зурвас газрын мэдээллийн сан хөтлөх, баяжуулалт хийх. | Сумын төвийн халаалтын шугам болон 0,4 цахилгааны шугамыг хамгаалалтын бүс, зурвас газрын мэдээллийн санд оруулах | **5** | **4** |
| | **4.1.6. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэс**<br>- Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийн эргэлтийн цэг, шугамыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байдал */Газар олголт, бэлчээр, хадлангийн газар ашиглалт/* (5 оноо)<br>- Өвөлжөө, хаваржааны газрын маргаантай газрыг сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж шийдвэрлэсэн байдал (5 оноо) | Өвөлжөө, хаваржааны газрын маргаантай 5 газрыг 2022 оны сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж шийдвэрлэсэн байна. | **10** | **10** |
| **4.2.Тусгай хэрэгцээний газрын бүртгэл, судалгаа** | **4.2.1. Тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалт**<br>- Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан тогтоол, шийдвэрийн бүртгэл, мэдээллийн санг хөтөлсөн байдал | 2022 онд орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газар байхгүй. | **10** | **10** |
| **4.3. Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем** | **4.3.1. Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем**<br>- Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд агентлагийн даргын 2020 оны А/40 дүгээр тушаалаар батлагдсан "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журам"-ын дагуу хөтөлсөн байдал (10 оноо)<br>- www.egazar.gov.mn хаягаар дамжуулж, аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хотын хөгжлийн төлөвлөгөөг олон нийтэд мэдээлэл хүргэж, санал авсан байдал (5 оноо) | Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд агентлагийн даргын 2020 оны А/40 дүгээр тушаалаар батлагдсан "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журам"-ын дагуу хөтлөсөн. Цахим хуудсанд санал авах мэдээлэл тогтмол байршуулж багийн иргэдийн нийтийн хурал иргэдээс цаасаар санал авдаг. | **15** | **10** |
| **5. Кадастрын ажлын явц, үр дүн** | | | **100** | **85** |
| **5.1. Кадастрын ажлын явц, үр дүн** | **5.1.1. Газрын нэгдмэл сангийн мэдээллийн сангийн хөтлөлт, тайлан** | Газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд өөрчлөлтийг тухай бүр оруулж ажилладаг. | **10** | **10** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | - Газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд өөрчлөлт оруулж буй байдал<br>- Газрын нэгдмэл сангийн тайлан гаргалт, архивласан байдал<br>- Төрийн өмчийн газрын бүртгэл хөтлөлт, гэрээгээр хүлээлгэн өгсөн байдал | | | |
| | **5.1.2. Кадастрын мэдээллийн нэгдсэн системийн ашиглалт**<br>- Газар өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой өргөдлийн бүртгэл, түүний шийдвэрлэлт /25 өргөдлийн төрөл тус бүрээр/<br>- Иргэн аж ахуй нэгжээс өргөдлийг цахимаар авч шийдвэрлэсэн байдал /цахимаар авсан өргөдлийн тоо/<br>- Өмчлүүлсэн газрын бүртгэл хөтөлсөн байдал<br>- Газар эзэмших, ашиглах эрхийн бүртгэл хөтөлсөн байдал<br>- Газар эзэмших, ашиглах эрх олгосон шийдвэрийн дагуу иргэн, аж ахуйн нэгжийн газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ болон гэрээг цахимжуулан дундын мэдээллийн санд илгээсэн байдал<br>- Нэгж талбарын талбайн хэмжээ болон зориулалтыг захирамжийн дагуу бүртгэсэн байдал<br>- Нэгж талбарын хаягийг холбогдох журмын дагуу бүртгэсэн байдал<br>- Барьцааны бүртгэл хөтөлсөн байдал<br>- Орон нутгийн тусгай хэрэгцээний газрыг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэсэн байдал | 2022 онд иргэдээс өргөдөл хүсэлт ирүүлээгүй.<br>Мэдээллийн санд өмчлөлийн 184, эзэмшлийн 295 нэгж талбар бүртгэлтэй.<br>Зөрчилтэй 150 нэгж талбар байснаас 86 нэгж талбарын зөрчлийг арилгасан.<br>Мэдээллийн санд 137 цахим өргөдөлийг бүртгэсэн.<br>Нэгж талбарын талбайн хэмжээ болон зориулалтыг өөрчлөх хүсэлт ирээгүй.<br>Хаягийн мэдээллийн санг журмын дагуу хөтөлсөн.<br>Барьцааны 2 бүртгэлийг хөтөлсөн.<br>**Зөвлөмж:** Цаашид иргэн, аж ахуй нэгжээс өргөдөл, хүсэлтийг цахимаар авч шийдвэрлэх.<br>Нөхөн бүрдүүлэлтээр мэдээллийн санд оруулах 5 нэгж талбарыг оруулах.<br>Зөрчилтэй 64 нэгж талбарыг тухайн жилийн ГЗБТ-нд тусгаж, сумын Засаг даргын захирамжаар зөрчлийг арилгах.<br>Эзэмшил өмчлөлийн газрын 342 нэгж талбарын цахим архив болон цаасан архивыг үүсгэж архивлах. | **20** | **15** |
| | **5.1.3. Кадастрын зураглалын ажлын хяналт**<br>- Кадастрын зураглалыг "Кадастрын зураглалын ажил" БНБД 11-11-16-ын дагуу хийж буй байдал<br>- "Нэгж талбарын эргэлтийн цэгийг газарт бэхлүүлэх мэдэгдэл"-ийг холбогдох мэргэжлийн байгууллагад хүргүүлсэн байдал<br>- Нэгж талбарын эргэлтийн цэгийг газарт бэхэлж, акт үйлдсэн байдал<br>- Бэхлэгдсэн эргэлтийн цэгийн дагуу нэгж талбарын хилийн заагийг тогтоож буй байдал | "Нэгж талбарын эргэлтийн цэгийг газарт бэхлүүлэх мэдэгдэл", нэгж талбарын эргэлтийн цэгийг газарт бэхэлж, акт үйлдсэн байдал, бэхлэгдсэн эргэлтийн цэгийн дагуу нэгж талбарын хилийн заагийг тогтоож буй байдал журмын дагуу хийгдэж байна. | **10** | 10 |
| | **5.1.4. Газрын зөрчил, маргаан шийдвэрлэлт**<br>- Зөрчилтэй нэгж талбарын судалгаа гаргаж зөрчил арилгасан байдал | Зөрчилтэй 150 нэгж талбар байснаас 86 нэгж талбарын зөрчлийг арилгасан. | **15** | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | - Иргэн, хуулийн этгээдээс гаргасан газрын маргаантай өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэсэн байдал<br>- Шүүх байгууллагын шинжээчийн дүгнэлт болон нотлох баримтыг шаардлагын дагуу хугацаанд нь хүргүүлсэн байдал | Зөрчилтэй 64 нэгж талбарыг тухайн жилийн ГЗБТ-нд тусгаж, сумын Засаг даргын захирамжаар зөрчлийг арилгах. Иргэн, хуулийн этгээдээс гаргасан газрын маргаантай өргөдөл, хүсэлт ирээгүй.<br>Шүүх байгууллагын шинжээчийн дүгнэлт болон нотлох баримт гаргуулах хүсэлт ирээгүй. | | 15 |
| | **5.1.5. Нэгж талбарын хувийн хэргийн бүрдүүлэлт**<br>- Шинээр үүссэн эрхийн нэгж талбарын хувийн хэргийг цахимаар болон цаасаар үүсгэсэн байдал<br>- Нэгж талбарын хувийн хэргийг зохих журмын дагуу бүрдүүлсэн байдал<br>- Өмчлөл, эзэмшил, ашиглалтын газрыг газрын мэдээллийн санд бүрэн гүйцэт оруулж дуусгасан байдал | Мэдээллийн санд өмлөлийн 184, эзэмшлийн 295 нэгж талбар бүртгэлтэй.<br>Мэдээллийн санд нийт 419 нэгж талбар бүртгэлтэй байгаагаас 77 нэгж талбар дээр цахим архив үүсгэсэн байна.<br>**Зөвлөмж**:Эзэмшил өмчлөлийн газрын 342 нэгж талбарын цахим архив болон цаасан архивыг үүсгэж архивлах. | **15** | 10 |
| | **5.1.6. Газрын биржийн цахим системийн ашиглалт**<br>- Дуудлага худалдааны мэдээ, мэдээллийг цахим системд хөтөлсөн байдал<br>- Цахим дуудлага худалдаа зохион байгуулсан байдал<br>- Төсөл сонгон шалгаруулалтын мэдээ, мэдээллийг цахим системд хөтөлсөн байдал<br>- Төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулсан байдал<br>- Газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ цуглуулж, бүртгэсэн байдал<br>- Газрын биржийн цахим системийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, таниулах арга хэмжээ авсан байдал | 2022 оны ГЗБТ-нд 6 байршилд дуудлага худалдаа зохион байгуулахаар төлөвлөсөн байснаас бүгдийг цахимаар зохион байгуулж 5 дуудлага худалдаа амжилттай болж сумын Засаг даргын захирамжаар газар эзэмшүүлсэн. 1 дуудлага худалдаанд иргэн оролцоогүй.<br>2021 онд газар эзэмших эрх шилжсэн 1 үнийн мэдээг цахим биржид бүртгэсэн. 2022 онд газар эзэмшүүлэх эрх шилжүүлэх хүсэлт ирээгүй.<br>Дуудлага худалдаа зарлагдах бүрт иргэдэд газрын биржийн цахим системийг сурталчлан ажилладаг.<br>**Зөвлөмж:** Дуудлага худалдааны ялагчийн материалыг нэгж талбарын хувийн хэрэгт хадгалах.<br>Зарын дагуу үнийн мэдээг цуглуулж газрын цахим биржид оруулах. | **15** | **15** |
| | **5.1.7. Газрын төлбөр, татварын системийн ашиглалт**<br>- Газрын төлбөрийн төлөвлөгөө боловсруулсан байдал<br>- Газрын төлбөрийн ногдуулалт хийсэн байдал<br>- Газрын төлбөрийн нэхэмжлэх үүсгэсэн байдал<br>- Улсын тэмдэгтийн хураамжийн төлбөрийн даалгавар үүсгэсэн байдал<br>- Хураамжийн орлогын төлбөрийн даалгавар үүсгэсэн байдал | 271 нэгж талбар дээр ногдуулалт нэхэмжлэл үүссэн. Татвар төлөгчөөр бүртгэгдээгүй 22 нэгж талбарын нэхэмжлэл үүсээгүй.<br>Газрн төлбөрийн төлөвлөгөөг газрын кадастрын системийн төлбөрийн тайлан хэсгээс татан авч ангилал тус бүрээр гаргаж өгдөг.<br>**Зөвлөмж:** Татварын байцаагчтай хамтран Нэхэмжлэл үүсээгүй 22 нэгж талбарын | **15** | **10** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | нэхэмжлэлийг үүсгэх. Газрын төлбөрийн 2022 оны нэхэмжлэл үүссэн газрын төлбөрийн зөрүүг нөхөн төлбөрөөр авч газрын төлбөрийн нэхэмжлэлийг шинэчлэх<br>Улсын тэмдэгтийн хураамжийн төлбөрийн даалгаврыг өргөдлийн бүртгэл хэсгээс үүсгэж байх.<br>www.egazar.gov.mn сайтаар газрын төлбөр хэрхэн төлөх талаар иргэдэд сурталчилж ажиллах. | | |
| **6. Архив, төрийн нууцын хадгалалт хамгаалалт, лабораторийн ажлын явц, үр дүн** | | | **100** | **70** |
| **6.1. Мэдээллийн хадгалалт, хамгаалалт, хангамж** | **6.1.1. Нэгж талбарын хувийн хэргийн хадгалалт хамгаалалт, кадастрын мэдээллийн үйлчилгээ**<br>- Нэгж талбарын хувийн хэргийн бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт<br>- Нэгж талбарын хувийн хэргийн баримтыг журам, зааврын дагуу архивласан байдал<br>- 2003-2010 онд иргэнд өмчлүүлсэн газрын нэгж талбарын хувийн хэргийг хүлээлгэж өгсөн байдал | Нэгж талбарын хувийн хэргийн баримтыг журам, зааврын дагуу архивласан.<br>2003-2010 онд иргэнд өмчлүүлсэн газрын нэгж талбарын хувийн хэргийг хүлээлгэж өгсөн.<br>**Зөвлөмж:** Нэгж талбарын хувийн хэргийн бүрдлийг дэс дараалалд оруулж, бүрдлийг бүрэн гүйцэт хангаж, хадгалалт хамгаалалтыг сайжруулах. | **100** | **70** |
| **7. Орон зайн мэдээлэл технологийн ажлын явц, үр дүн** | | | **100** | **90** |
| **7.1. Сүлжээ, техник хангамжийн хэвийн үйл ажиллагаа** | **7.1.1. Компьютер, техник хангамж хүрэлцээ, хангамж/10 оноо/**<br>- Техник хангамжийн хэвийн ажиллагаа, техник хангамжийн үзүүлэлт, шаардлага хангаж буй байдал<br>- Зохих горимын дагуу хэрэглэж байгаа эсэх<br>- Техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал | Техник, тоног төхөөрөмж хэвийн ажиллаж байгаа, байгууллагын эд хөрөнгөд бүртгэлтэй тоног төхөөрөмжүүд бүрэн бүтэн, өдөр тутмын үйл ажиллагаанд хэвийн ашиглаж байна.<br>Шаардлагатай тоног төхөөрөмж: GPS | **50** | **50** |
| **7.2. Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй хэрэглээний програм хангамжийн хэвийн үйл ажиллагаа** | **7.2.1. Байгууллагын цахим хуудсын хөтлөлт**<br>- Байгууллагын цахим хуудсанд тогтмол мэдээ, мэдээлэл оруулсан байдал<br>- Салбарын хууль, тогтоомж, цаг үеийн мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэсэн байдал<br>- Олон нийтийн сүлжээний ашиглалт, хүртээмж | Хулд суумын газрын даамал фэйсбүүк хуудас 369 дагагчтай.<br>Салбарын хууль тогтоомж, ГЗБТ, тайлан, мэдээ мэдээллийг мэдээллийн самбарт тогтмол байршуулж, иргэдэд сурталчилдаг.<br>**Зөвлөмж:** Фэйсбүүк хуудсандаа үйл ажиллагаагаа тогтмол сурталчилж, мэдээ мэдээллийг шинэчилж байх. | **50** | **40** |
| **Дундаж оноо** | | | **77.1** | |

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

ГУХ-ЫН ДАРГА: Б.РЭНЦЭНДОРЖ

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ,
ӨМЧЛӨЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН: Т.САРАНЗУЛ
КАДАСТРЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Б.БАТЦЭЦЭГ
ГАЗРЫН ТӨЛБӨР, ТАТВАР, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Д.БОЛОРЧИМЭГ
ГЕОДЕЗИ ЗУРАГЗҮЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ж.ЭЛБЭГЗАЯА
СУУРЬ СУДАЛГАА МОНИТОРИНГИЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ц.ХАДАМДАРАМ
ҮНЭЛГЭЭТЭЙ ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДААМАЛ: Н.ЖАВДАЛ